ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДГА-2024/157/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.dornogovi@audit.gov.mn
Дорноговь аймаг
Сайншанд сум
2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 70522734
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас:70523020
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Э.Эрдэнэсувд
Цахим хаяг: erdenesuvde@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА


**1.АУДИТЫН ДҮГНЭЛТ** 2

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** 5

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** 12

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** 14


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БШУС | Боловсрол шинжлэх ухааны сайд |
| БШУГ | Боловсрол Шинжлэх Ухааны газар |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| МУ | Монгол Улс |
| МУЕА | Монгол Улсын ерөнхий аудитор |
| ЗГ | Засгийн газар |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| АШБ | Анхан шатны баримт |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| НХМ | Нэг хэвийн маягт |

## 1.АУДИТЫН ДҮГНЭЛТ

ДОРНОГОВЬ АЙМАГ
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024.02.23 № 1-6/60

танай____________-ны №____________-т

САЙНШАНД СУМЫН ЛАБОРАТОРИ ХОЁРДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.АЗЗАЯА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын ерөнхий боловсролын лабортари 2 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сайншанд сумын ерөнхий боловсролын лабортари 2 дугаар сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус байгууллага нь тайлант оны 12 дугаар сарын 31-ны байдлаар payroll цалингийн программаар 2,146.1 сая төгрөгийн цалин хөлс тооцоолон олгосон боловч нийгмийн даатгалын шимтгэлийн байгууллагад 36.7 сая төгрөг дутуу тайлагнаж, тооцоо нийлсэн үлдэгдлийн баталгаагаар баталгаажаагүй, 7,8 дугаар сарын амралтын цалингийн тооцооны хүснэгт байхгүй байгаа нь санхүүгийн байдлын тайланд тусгагдсан өглөг, авлага, үр дүнгийн тайланд тусгагдсан цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.7-д "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 25 дугаар зүйлийн 25.1.1-т "энэ хуулийн 14 дэх зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1-т "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ:1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх; 2/шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын

0100030231

байгууллагад ирүүлэх" гэж заасантай тус тус нийцээгүй, залруулаагүй зөрчлийн нийт дүн 36,703.2 мянган төгрөг нь тогтоосон материаллаг байдлын түвшин 7,344.7 мянган төгрөгөөс их байгаа нь өөрчлөлттэй дүгнэлт өгөх үндэслэл бүхий байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 107, 489, 491 дүгээр тогтоол, 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотой цалингийн сан нэмэгдсэн байна.

Тайлант онд Сайншанд сумын ерөнхий боловсролын лабортари 2 дугаар сургуулийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг Улсын төсвийн хөрөнгө оруулалт 4,151.6 сая төгрөгөөр гүйцэтгүүлэн ашиглалтад хүлээн авсан байна.

**Аудитын гол асуудал**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад тайлант онд 8 төрлийн мэдээ тайлан, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3.168.6 сая төгрөгийн 53 орлогын гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 234.3 сая төгрөгийн 10 зарлагын гүйлгээг тус тус байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилго, 10 үндсэн зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.
АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.
Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.
Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **346,031,339.13** | **417,212,638.81** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 62,496,838.94 | 229,217,599.93 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 62,496,838.94 | 229,217,599.93 |
| **3121** | **Төгрөг** | 62,496,838.94 | 229,217,599.93 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 48,106,648.00 | 194,028,108.99 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 14,390,190.94 | 35,189,490.94 |
| **33** | **АВЛАГА** | 98,180,120.00 | 829,947.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 829,947.00 |
| **335** | **Бусад авлага** | 98,180,120.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 97,290,120.00 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 890,000.00 | - |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 1,785,000.00 | - |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 1,785,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 183,569,380.19 | 187,165,091.88 |
| **351** | **Түүхий эд материал** | 42,350,231.10 | 33,595,874.10 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 41,693,031.10 | 32,784,291.10 |
| 35130 | Эм боох материал | 657,200.00 | 811,583.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 141,219,149.09 | 153,569,217.78 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,613,460.00 | 835,280.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 7,982,411.95 | 11,078,858.76 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 80,000.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 131,543,277.14 | 141,655,079.02 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,076,322,753.00** | **7,422,379,238.41** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,076,322,753.00 | 7,422,379,238.41 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,685,239,148.64 | 7,031,727,383.97 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,505,552,651.37 | 6,657,143,206.37 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (255,510,017.88) | (323,703,537.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 405,461,577.98 | 721,979,097.98 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (187,770,414.89) | (282,377,510.87) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 170,172,571.01 | 233,662,555.01 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (85,072,941.67) | (110,221,342.26) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 23,955,631.47 | 23,955,631.47 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (3,881,739.96) | (6,031,803.84) |
| 39217 | Ном | 112,331,831.21 | 117,321,087.11 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 391,083,604.36 | 390,651,854.44 |
| 39301 | Програм хангамж | 1,727,000.00 | 1,727,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,043,395.64) | (1,475,145.56) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 390,400,000.00 | 390,400,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,422,354,092.13** | **7,839,591,877.22** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **11,249,678.77** | **24,875,662.60** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 11,249,678.77 | 24,875,662.60 |
| **413** | **Өглөг** | 11,249,678.77 | 24,875,662.60 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 10,796,278.77 | 22,709,212.73 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 25,500.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 453,400.00 | 2,140,949.87 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 363,400.00 | 701,900.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 90,000.00 | 1,439,049.87 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,411,104,413.36** | **7,814,716,214.62** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,411,104,413.36 | 7,814,716,214.62 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,411,104,413.36 | 7,814,716,214.62 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,411,104,413.36 | 3,410,214,413.36 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 4,404,501,801.26 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 3,422,354,092.13 | 7,839,591,877.22 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **6,286,710,509.32** | **7,540,672,181.31** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,463,360,181.80** | **4,366,745,183.78** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,457,648,181.80 | 4,366,745,183.78 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 18,116,619.00 | 20,686,987.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,421,002.00 | 16,501,339.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,695,617.00 | 4,185,648.00 |
| 120009 | Бусад орлого | 2,184,577.09 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 3,252,725,956.31 | 4,337,605,194.90 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 184,621,029.40 | 8,453,001.88 |
| **122** | **Тусламжийн орлого** | 5,712,000.00 | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 5,712,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,823,350,327.52** | **3,173,926,997.53** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,539,822,000.00 | 2,904,854,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,539,822,000.00 | 2,904,854,200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 283,528,327.52 | 269,072,797.53 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 283,528,327.52 | 269,072,797.53 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,891,100,247.96** | **3,136,170,380.05** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,891,100,247.96** | **3,136,170,380.05** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,695,951,747.96 | 2,963,458,080.05 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,900,812,147.32 | 2,109,993,580.20 |
| 210101 | Үндсэн цалин | 1,321,934,150.62 | 1,406,728,951.55 |
| 210102 | Нэмэгдэл | 550,285,214.85 | 653,375,214.30 |
| 210104 | Урамшуулал | 28,592,781.85 | 49,889,414.35 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 236,529,489.45 | 273,668,068.76 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 168,945,172.95 | 188,575,822.85 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,599,633.37 | 21,605,359.63 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 13,995,706.66 | 17,284,027.71 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,534,475.93 | 4,187,941.32 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 32,454,500.54 | 42,014,917.25 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 243,774,227.10 | 261,072,797.53 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,695,370.42 | 14,335,757.53 |
| 210302 | Түлш, халаалт | 206,360,000.00 | 229,080,640.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 22,718,856.68 | 17,656,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,744,540.22 | 37,441,480.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,447,990.00 | 23,349,148.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 260,000.00 | 80,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 71,300.00 | 48,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 154,600.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,755,359.34 | 4,055,592.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 8,055,290.88 | 9,908,740.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 43,512,407.85 | 444,502.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,323,220.00 | 438,502.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 40,452,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,737,187.85 | 6,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,127,900.14 | 6,467,981.19 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 202,900.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,200.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 10,920,800.14 | 6,467,981.19 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,764,804.09 | 30,266,418.55 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,040,804.09 | 10,034,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,724,000.00 | 20,231,918.55 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 227,686,231.79 | 244,103,251.82 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,984,980.00 | 42,219,472.33 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 29,047,265.00 | 11,352,950.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 165,653,986.79 | 190,530,829.49 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 195,148,500.00 | 172,712,300.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 195,148,500.00 | 172,712,300.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 12,675,000.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 181,978,500.00 | 166,747,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 495,000.00 | 5,964,800.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **3,395,610,261.36** | **4,404,501,801.26** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 14,081,717.52 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 14,081,717.52 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (14,081,717.52) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **3,381,528,543.84** | **4,404,501,801.26** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,868,830,487.46** | **3,229,044,984.53** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **45,491,809.94** | **55,117,987.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 45,491,809.94 | 55,117,987.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 18,116,619.00 | 20,686,987.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,421,002.00 | 16,501,339.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,695,617.00 | 4,185,648.00 |
| 120009 | Бусад орлого | 27,375,190.94 | 34,431,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,823,338,677.52** | **3,173,926,997.53** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,539,822,000.00 | 2,904,854,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,539,822,000.00 | 2,904,854,200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 283,516,677.52 | 269,072,797.53 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 283,516,677.52 | 269,072,797.53 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,803,001,148.52** | **2,960,632,223.54** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,803,001,148.52** | **2,960,632,223.54** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,567,949,048.52** | **2,787,855,223.54** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,890,989,345.00 | 2,137,253,111.37 |
| 210101 | Үндсэн цалин | 1,336,222,001.37 | 1,429,857,582.72 |
| 210102 | Нэмэгдэл | 538,814,834.48 | 657,506,114.30 |
| 210104 | Урамшуулал | 15,952,509.15 | 49,889,414.35 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 235,586,013.00 | 268,735,703.09 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 160,207,066.43 | 183,643,457.18 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 18,847,919.36 | 21,605,359.63 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,078,255.51 | 17,284,027.71 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,768,424.68 | 4,187,941.32 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 37,684,347.02 | 42,014,917.25 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 243,774,199.52 | 261,072,797.53 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,695,342.84 | 14,335,757.53 |
| 210302 | Түлш, халаалт | 206,360,000.00 | 229,080,640.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 22,718,856.68 | 17,656,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,787,720.00 | 8,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,787,720.00 | 8,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,369,100.00 | 28,567,918.55 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,645,100.00 | 10,034,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,724,000.00 | 18,533,418.55 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 175,442,671.00 | 84,225,693.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 141,472,907.00 | 52,980,342.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 33,969,764.00 | 31,245,351.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **235,052,100.00** | **172,777,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 235,052,100.00 | 172,777,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 12,585,000.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 222,067,100.00 | 166,722,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 400,000.00 | 6,055,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **65,829,338.94** | **268,412,760.99** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **3,332,500.00** | **203,384,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3,332,500.00** | **203,384,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 3,332,500.00 | 203,384,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 101,692,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3,332,500.00 | 101,692,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(3,332,500.00)** | **(203,384,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 62,496,838.94 | 65,028,760.99 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 62,496,838.94 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 62,496,838.94 | 229,217,599.93 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | 29,506,569.52 | | 29,506,569.52 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **29,506,569.52** | **-** | 29,506,569.52 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 3,381,597,843.84 | | 3,381,597,843.84 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **3,411,104,413.36** | **-** | 3,411,104,413.36 |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **3,411,104,413.36** | **-** | 3,411,104,413.36 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (890,000.00) | | (890,000.00) |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **3,410,214,413.36** | **-** | 3,410,214,413.36 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 4,404,501,801.26 | | 4,404,501,801.26 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **7,814,716,214.62** | **-** | 7,814,716,214.62 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

(төгрөгөөр)

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | | **Хэтрэлт хэмнэлт** | **Хувь** |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 3,337,279,000.00 | 3,048,692,523.54 | 288,586,476.46 | 91.35 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3,337,279,000.00 | 3,048,692,523.54 | 288,586,476.46 | 91.35 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,115,824,100.00 | 2,881,970,523.54 | 233,853,576.46 | 92.49 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,230,511,900.00 | 2,137,253,111.37 | 93,258,788.63 | 95.82 |
| 210101 | Үндсэн цалин | 1,500,099,700.00 | 1,429,857,582.72 | 70,242,117.28 | 95.32 |
| 210102 | Нэмэгдэл | 657,471,100.00 | 657,506,114.30 | (35,014.30) | 100.01 |
| 210104 | Урамшуулал | 72,941,100.00 | 49,889,414.35 | 23,051,685.65 | 68.40 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 278,814,000.00 | 268,735,703.09 | 10,078,296.91 | 96.39 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 189,593,500.00 | 183,643,457.18 | 5,950,042.82 | 96.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 22,305,200.00 | 21,605,359.63 | 699,840.37 | 96.86 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 17,844,100.00 | 17,284,027.71 | 560,072.29 | 96.86 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,461,000.00 | 4,187,941.32 | 273,058.68 | 93.88 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 44,610,200.00 | 42,014,917.25 | 2,595,282.75 | 94.18 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 353,354,600.00 | 261,072,797.53 | 92,281,802.47 | 73.88 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 18,750,000.00 | 14,335,757.53 | 4,414,242.47 | 76.46 |
| 210302 | Түлш, халаалт | 312,235,000.00 | 229,080,640.00 | 83,154,360.00 | 73.37 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 22,369,600.00 | 17,656,400.00 | 4,713,200.00 | 78.93 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,000,000.00 | 8,000,000.00 | - | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,000,000.00 | 8,000,000.00 | - | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 33,326,500.00 | 28,567,918.55 | 4,758,581.45 | 85.72 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,298,700.00 | 10,034,500.00 | 2,264,200.00 | 81.59 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 21,027,800.00 | 18,533,418.55 | 2,494,381.45 | 88.14 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 211,817,100.00 | 178,340,993.00 | 33,476,107.00 | 84.20 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 180,275,300.00 | 147,095,642.00 | 33,179,658.00 | 81.60 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 31,541,800.00 | 31,245,351.00 | 296,449.00 | 99.06 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 221,454,900.00 | 166,722,000.00 | 54,732,900.00 | 75.28 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 221,454,900.00 | 166,722,000.00 | 54,732,900.00 | 75.28 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 221,454,900.00 | 166,722,000.00 | 54,732,900.00 | 75.28 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3,337,279,000.00 | 3,194,613,984.53 | 142,665,015.47 | 95.73 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,975,924,400.00 | 2,904,854,200.00 | 71,070,200.00 | 97.61 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,975,924,400.00 | 2,904,854,200.00 | 71,070,200.00 | 97.61 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 361,354,600.00 | 269,072,797.53 | 92,281,802.47 | 74.46 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 361,354,600.00 | 269,072,797.53 | 92,281,802.47 | 74.46 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | 20,686,987.00 | (20,686,987.00) | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 16,501,339.00 | (16,501,339.00) | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 4,185,648.00 | (4,185,648.00) | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **48,106,648.00** | (48,106,648.00) | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **194,028,108.99** | (194,028,108.99) | |

## 2.6 Аудит хийсэн ахмадын сангийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн |
|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **13,631,700.00** | **(13,631,700.00)** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **13,631,700.00** | **(13,631,700.00)** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **13,631,700.00** | **(13,631,700.00)** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **-** | **-** | **-** |
| **210901** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | **7,576,700.00** | **(7,576,700.00)** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 6,055,000.00 | **(6,055,000.00)** |
| **1** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | 34,431,000.00 | **(34,431,000.00)** |
| **35** | **ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **-** | 34,431,000.00 | **(34,431,000.00)** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 34,431,000.00 | **(34,431,000.00)** |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **14,390,190.00** | **(14,390,190.00)** |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **35,189,490.00** | **(35,189,490.00)** |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,185.9 сая төгрөгийн 2 алдаа[1] илэрснээс аудитын явцад 4,185.9 сая төгрөгийн 2 алдааг залрууллаа.

**Залруулсан алдаа:**

1. Тайлант онд мөнгөн гүйлгээний тайланд 34.3 сая төгрөгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг алдаатай бүртгэснийг залруулав.
2. Тайлант онд Улсын төсвийн 4,151.5 сая төгрөгийн 320 хүүхдийн хичээлийн байр шинээр ашиглалтад орж, санхүүгийн тайлан балансад орлогоор бүртгээгүйг залруулан данс бүртгэлд тусгасан.

Аудитаар нийт 2 зөрчил[2] илэрснээс, 36.7 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 36,703.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 20,756.1 мянган төгрөгөөр их тул **“Хязгаарлалттай”** дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

**1. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлагналтай холбоотой асуудал**

Тус байгууллагын цалингийн зардал 2,146.1 сая төгрөг бөгөөд нийгмийн даатгалын байгууллагад 2,109.4 сая төгрөгөөр, татварын байгууллагад 1,902.3 сая төгрөгөөр тус тус тайлагнасан. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д “*цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого*”, 25 дугаар зүйлийн 25.1.1-д “*энэ хуулийн 14 дэх зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх*”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1-т “*Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ:1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх; 2/шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх*” заалтуудтай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 5.2 Зөвлөмж

**1. Шилэн данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад тайлант онд 8 төрлийн мэдээ тайлан, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3.168.6 сая төгрөгийн 53 орлогын гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 234.3 сая төгрөгийн 10 зарлагын гүйлгээг тус тус байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
Үр дагавар: Хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Өгсөн зөвлөмж:* Хуулийн хэрэгжилтийг ханган, шилэн дансны системд нэвтрэх ерөнхий эрхээс мэдээ тайланг хариуцах албан хаагчийг хуваарилан, хуулийн хугацаанд мэдээ тайланг байршуулах.

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтүүдийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Мөнгөн гүйлгээний тайланд зардлыг алдаатай илэрхийлсэн. | 1 | 34,362.0 | | | 1 | 34,362.0 | 1 | 34,362.0 | | |
| Үндсэн хөрөнгийн орлого дутуу бүртгэсэн | 1 | 4,151,590.5 | 1 | 4,151,590.5 | | | 1 | 4,151,590.5 | | |
| **Дүн** | **2** | **4,185,952.5** | **1** | **4,151,590.5** | **1** | **34,362.0** | **2** | **4,185,952.5** | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Тайлант онд 8 төрлийн мэдээ тайлан, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3.168.6 сая төгрөгийн 53 орлогын гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 234.3 сая төгрөгийн 10 зарлагын гүйлгээг тус тус байршуулаагүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| **Дүн** | **1** | | **-** | **-** | **-** | **-** | **1** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцох албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тус байгууллагын цалингийн зардал 2,146.1 сая төгрөг бөгөөд нийгмийн даатгалын байгууллагад 2,109.4 сая төгрөгөөр, татварын байгууллагад 1,902.3 сая төгрөгөөр тус тус тайлагнасан. | 1 | 36,703.2 | - | - | 1 | 36,703.2 | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **1** | **36,703.2** | **-** | **-** | **1** | **36,703.2** | **-** | **-** | | | | |